



**Арилжааны мэдээ**

- Монголын хөрөнгийн бирж 2018 оны 1 дүгээр сарын 28-ны өдрөөс 2019 оны 2 дугаар сарын 2-ны өдрүүдэд 6 удаагийн үнэт цаасны арилжааг зохион байгуулж, өдөрт дунджаар 358.8 сая төгрөг буюу нийт 2,153,119,933 төгрөгийн арилжаа хийсэн байна.
- 2019 оны 02 дүгээр сарын 02-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,440,931,774,696.80 төгрөг болсон бол “ТОП 20” индекс 21475.93 нэгж болж өмнөх долоо хоногоос 0.45% хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- 1 дүгээр сарын 28-ны өдрөөс 2019 оны 2 дугаар сарын 2-ны өдрүүдэд ЗГҮЦ хоёрдогч зах зээлийн арилжаагаар 8,289 ширхэг үнэт цаас 846,408,330 төгрөгөөр арилжаалагдсан байна.

MSE Top 20 индекс

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Монгол банкны USD/MNT ерөнхий харьцаа

Эх сурвалж: Монгол Банк

Зах зээлийн өөрчлөлт

Индекс	Нэгж	% Өөрчлөлт
MSE Top-20 индекс	21475.93	0.45%
MSE A индекс	9617.4	-2.66%
MSE B индекс	8459.23	-2.44%

Зах зээлийн хураангуй	Нийт (MNT)
Зах зээлийн үнэлгээ	2,440,931,774,696.80
Арилжигдсан үнийн дүн	2,153,119,933

Үнийн дүнгээр	Хаалт (MNT)	Мөнгөн дүн
ЛэндМН БСББ ХК	74.51	697,810,313.50
АПУ	609.89	138,660,757.8
ГОВЬ	338.98	134,971,182.65
ТАВАН ТОЛГОЙ	6170	120,920,705.00
МАНДАЛ ДААТГАЛ	5165	104,515,055.00

Тоо ширхэгээр	Хаалт (MNT)	Нийт
ЛэндМН БСББ ХК	74.51	9,597,131.00
ГОВЬ	338.98	406,682.00
АПУ	609.89	228,933.00
РЕМИКОН	27	88,877.00
СҮҮ	210	54,564.00

Ханш өссөн	Хаалт (MNT)	% Өөрчлөлт
ШИВЭЭ ОВОО	2280	14.00
ЛЭНДМН БСББ ХК	74.51	11.38
СҮҮ	210	4.82
УБ-БҮК	400	3.90
ГОВЬ	338.98	2.56

Ханш буурсан	Хаалт (MNT)	% Өөрчлөлт
МЕРЕКС	24	-25.00
МОНГОЛ САВХИ	480	-20.00
ХӨХ ГАН	68	-15.00
ХЭРЛЭН ХИВС	87	-14.03
ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	110000	-11.43

Тодруулга

Энэхүү арилжааны мэдээ нь зөвхөн арилжааны болон санхүүгийн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Энэхүү мэдээнд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “БиДиСек ҮЦК” ХК хариуцлага хүлээхгүй болно.

ЭНЭ ДОЛОО ХОНОГ**ДОТООДЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ДНБ-ИЙ 9 ХУВЬТАЙ ТЭНЦЛЭЭ. (bloombergtv.mn)**

Дотоодын хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 2018 оны эцэст хоёр их наяд 510 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 2.9 хувиар өсөөд байна. Ингэснээр хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ дотоодын нийт бүтээгдэхүүний есөн хувьтай тэнцэх болсныг Санхүүгийн зохицуулах хороо онцоллоо. Үүнд “Топ 20” индекс 2.7 хувиар өсөхөөс гадна дотоодын хөрөнгийн захад олон шинэ бүтээгдэхүүн гарсан нь голлох нөлөө үзүүлжээ.

2017 онд “Топ 20” индекс 70 орчим хувиар өссөнтэй харьцуулахад 2018 онд гол индекс үл ялиг дээшилсэн байна. Харин 2018 онд дөрвөн компани IPO гаргаж, Торонтогийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй нэг компанийг дотооддоо давхар бүртгэж, нэг компани нэмж хувьцаа гаргасан юм. Эдгээр компаниуд дотоодын хөрөнгийн заххаас нийт 30 гаруй тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн байна. Өөрөөр хэлбэл энэ хэмжээгээр зах зээлийн үнэлгээг өргөжээ. Мөн зах зээлд шинээр гарсан эдгээр зургаан бүтээгдэхүүний дөрвийнх нь ханш 2018 оны эцсийн байдлаар нэрлэсэн үнээсээ өсөөд байсан юм.

Монголын Хөрөнгийн бирж 2018 онд дотоодын компанийг бүртгэлээс хассан бол эдгээр компаниудын дийлэнх нь арилжааны идэвх сул, үүргийн хэрэгжилт хангалтгүй компаниуд байжээ. 2018 онд хөрөнгийн зах зээлд олон шинэ амжилт тогтоосны нэг нь хувьцааны арилжааны идэвх нэмэгдсэн явдал байлаа. Тоогоор илэрхийлбэл 210 тэрбум төгрөгт хүрч өссөн нь урд өмнө нь байгаагүй өндөр үзүүлэлт болжээ. Энэ нь хувьцааны хөрвөх чадварын үзүүлэлтэд огцом өөрчлөлт авчирсан байна. Өөрөөр хэлбэл 2018 онд хөрвөх чадвар 8.4 хувьд хүрч, 2017 оныхоос 5.2 пунктээр өсжээ.

“ТҮМЭН ШУВУУТ” ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЗАХИАЛГА 10.9 ТЭРБУМ ТӨГРӨГ ХҮРЧ ХААГДАВ. (bloombergtv.mn)

“Түмэн шувуут” компанийн анхдагч зах зээлийн арилжаа пүрэв гарагт дуусаж, нийт 10 тэрбум 915 сая төгрөгийн захиалга авсан байна. Энэ нь нийлүүлэлтээс 9.1 хувиар давсан үзүүлэлт боллоо. Тус компани нийт хувьцааныхаа 25 хувийг олон нийтэд санал болгожээ.

Өөрөөр хэлбэл 50 сая ширхэг хувьцааг нэг бүрийг нь 200 төгрөгөөр үнэлэн IPO гаргаж байна. Ийнхүү 2019 оны анхны IPO захиалгаа авч дууссанаар андеррайтер компани нь Санхүүгийн зохицуулах хороонд үнэт цаас худалдан авах захиалгуудын тайланг хүргүүлнэ. Үүний дараа Санхүүгийн зохицуулах хороо хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрөл олгох юм.

“Түмэн шувуут”-аас дөрөвдүгээр сараас өмнө даатгалын хоёр компани IPO гаргаж, дотоодын хөрөнгийн заххаас 13 орчим тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн байна. Ирэх 2, 3 сарын хугацаанд ч дахин хоёр компани IPO гаргахаар төлөвлөж байгаа зах зээлийн нийлүүлэлт ихтэй энэ үед “Түмэн шувуут” компани олон нийтээс 10 тэрбум төгрөгийг татлаа.

ХУВЬЦААНЫ ТӨВЛӨРЛИЙГ БУУРУУЛАХ БОДЛОГО БАРИМТАЛЖ БАЙНА. (frc.mn)

Хувьцааны зах зээл дээр төвлөрөл хэт өндөр байх нь ихээхэн сөрөг талтай. Энэ нь хувьцааны ихэнх цөөн тооны том хувьцаа эзэмшигчийн мэдэлд байна гэсэн үг юм.

Манай улсын хувьцааны зах зээл хэт төвлөрөлтэй, хувьцааны хөрвөх чадвар тааруу, улмаар жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг зөрчигдөх эрсдэл бүхий шинж чанартай болоод багагүй хугацаа өнгөрч буй. Энэ нь эргээд зах зээлийн нэр хүндэд муугаар нөлөөлж, шинээр орж ирэх хөрөнгө оруулагчдын урсгалыг сааруулдаг. Иймд Санхүүгийн зохицуулах хороо төвлөрлийг цаашид нэмэгдүүлэхгүй байх, улмаар багасгах бодлогыг түлхүү баримталж байна.

“Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьцааг 1072 ширхэгээр эзэмшүүлсэнтэй холбоотойгоор иргэд үнэт цаасны дансаа шинээр нээлгэх нь эрс идэвхжиж байна. 2018 оны байдлаар үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид шинээр 398 255 данс нээгдсэн нь өмнөх оны мөн үеэс 20 дахин нэмэгдсэн дүн юм.

Үнэт цаасны дансаа нээлгэснээр иргэдийн хөрөнгийн зах зээлд оролцох идэвх нэмэгдэж байгаа ч хувьцааны төвлөрөл өндөр хэвээрээ байгаа юм. 2016 оноос хойш хувьцааны төвлөрөл бага зэрэг буурсан хэдий ч энэ өөрчлөлтийн хувь хэмжээ 0.01 хувиар илэрхийлэгдэхүйц бага байна.

“Эрдэнэс Монгол” таван сая ширхэг хүртэлх хувьцаа гаргана. (unuudur.mn)

Монголын бизнесийн зөвлөлийн нэгдүгээр сарын уулзалт болж өнгөрлөө. Уг уулзалтад оролцсон “Эрдэнэс Монгол”-ын гүйцэтгэх захирал П.Ганхүү компани нь таван сая ширхэг хүртэлх давуу эрхийн хувьцаа гаргаж, иргэдэд эзэмшүүлэх бэлтгэл ажил хангаж байгаагаа дуулгав.

Тус компанийн давуу эрхийн нэг ширхэг хувьцааг иргэн бүрт эзэмшүүлэх шийдвэрийг 2011 онд гаргаж байсан. Гэвч уг шийдвэрийг өдий хүртэл хэрэгжүүлээгүй юм. УИХ-аас гаргасан уг тогтоолыг өөрчлөн, хууль баталснаар иргэн бүр болон шинээр мэндлэх үрс “Эрдэнэс Монгол”-ын давуу эрхийн нэг ширхэг хувьцааг эзэмших эрхтэй болох нь.

Давуу эрхийн хувьцаа нь ногдол ашиг тогтмол авах эрхтэйгээрээ онцлогтой. Түүнчлэн тус компани эрдэс баялгийн бирж байгуулах, “Багануур”, “Шивээ-Овоо”-гийн нэмэлт хувьцаа, “Эрдэнэс” бонд гаргахаар ажиллаж байгааг гүйцэтгэх захирал нь танилцуулав.

ДАВХАР БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААСЫГ ХИЛ ДАМЖУУЛАН ХӨРВҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХАМТРАН АЖИЛЛАХ ХҮСЭЛТИЙГ СЗХ-НД ХҮРГҮҮЛЛЭЭ. (mse.mn)

МХБ-ийн хамгийн анхны давхар бүртгэлтэй компани болох “Эрдэнэ ресурс девелопмент корпорейшн”-ийн хувьцаа 2018 оны 06 сараас эхлэн Монголын хөрөнгийн зах зээлд арилжаалагдаж байгаа билээ. Тус компанийн хувьцааны 97 хувь нь Торонтогийн бирждээ, 3 хувь нь МХБ-д тус тус арилжаалагдаж байна. Уг компанийн хувьцаа нь одоогийн байдлаар гадаад, дотоодын захуудын хооронд хөрвөн арилжаалагдахгүй байгаа хэдий ч одоогийн хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд хувьцаа хөрвүүлэх боломжийг нээлттэй болгох боломжтой гэж үзэн, уг чиглэлд хамтран ажиллах саналыг МХБ-ээс СЗХ-нд өнөөдөр хүргүүлээ.

Хувьцааг хил дамнуулан хөрвүүлэх боломжийг нээлттэй болгосноор ханшийн тэнцвэртэй байдлыг хангах, дотоодын зах зээлд нийлүүлэлт нэмэгдэх, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, зэрэг олон талын ач холбогдолтойгоос гадна стратегийн орд газарт үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй бусад компаниудыг давхар бүртгэж, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг шинэ шатанд гаргахад чухал ач холбогдолтой билээ.



О.Уранбайгал

Харилцагчийн албаны менежер
И-мэйл: baigal@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1
8-р хороо, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар, Монгол улс
Утас: 976-7555-1919
Факс: 976-11-321763

Б.Билгүүн

Харилцагчийн алба, мэргэжилтэн
И-мэйл: bilguun@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1
8-р хороо, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар, Монгол улс
Утас: 976-7555-1919
Факс: 976-11-321763

Б.Онон

Харилцагчийн алба, мэргэжилтэн
И-мэйл: Onon.b@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1
8-р хороо, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар, Монгол улс
Утас: 976-7555-1919
Факс: 976-11-321763

Энэхүү арилжааны мэдээ нь зөвхөн арилжааны болон санхүүгийн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Энэхүү мэдээнд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “БиДиСек ҮЦК” ХК хариуцлага хүлээхгүй болно.